

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА ХЭСЭГ		
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”	
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх	
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө	
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага	
5.	Хэрэгжих хугацаа, үе шат	Хөтөлбөрийг 6 жилийн хугацаанд 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Нэг дэх үе шат: 2016-2019 он Хоёр дахь үе шат 2020-2023 он	
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b> шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p><b>Зорилт 2.</b> төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 3.</b> төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 4.</b> худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 6.</b> авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;</p> <p><b>Зорилт 7.</b> авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p>	
7.	Зардал	Төсөв /төгрөг ₮/	<b>24,962,400 ₮</b>
		Үүнд:	Төсөв
		1-р үе шат	14,308,900 ₮
		2-р үе шат	10,653,500 ₮
			Гүйцэтгэл 499,000

**Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг**

8	<p><b>4.1.1. Шударга хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр:</b></p>
<p align="center">УУХҮЯ, ЭБАТ</p>	<p><b>4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх:</b></p> <p>- Монгол улсын Засгийн газар 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 370 дугаар тогтоолоор тус яам нь 5 газар, 8 хэлтэс, 78 орон тоотой батлагдаж, 2019 онд батлагдсан 78 орон тоотойгоор ажилласан байна. Мөн яамны харъяа төрийн өмчит хуулийн этгээд болох Эрдэнэс таван толгой ХК, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, тус яамнаас хэрэгжүүлж буй Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл, Бэрхийн уурхайд түшиглэсэн уул уурхайн сургалт, судалгааны төв зэрэг салбар нэгжүүдин удирдлага, нийт 21 албан хаагч хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/ хянуулсан байна. Үүнээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /УУХҮЯ/-нд томилогдсон 8, албан тушаал ахисан буюу хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэнээр томилогдсон 5, яамны харъяа төрийн өмчит хуулийн этгээд, ТУЗ-д томилогдсон 3, бусад шалтгаанаар 4 мэдүүлэг хянуулсан байна. 2019 оны ХАСУМ-ийн бүртгэлийг яамны цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна. ХАСУМ-ийн бүртгэлийг хавсаргав. Хавсралт № 03</p>
	<p><b>4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан дэвшүүлэх</b></p> <p>- Шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албаны шинэтгэлийн ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангасан албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан дэвшүүлэн ажиллаж байна.</p> <p>- Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх ажлын хүрээнд УУХҮЯ ёс зүйн хороогоо шинэчлэн байгуулж, нийт албан хаагчиддаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулан гарын үсгээр баталгаажуулав.</p>
	<p><b>4.1.1.3. олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох</b></p> <p>- Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн 54 дүгээр зүйлд</p>

	<p>УУХҮЯ, ЭБАТ</p>	<p>Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлэхээр заасан. Хуулийн дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, 2020 оны 1 дүгээр сараас яам, газар хэлтэс, албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулахаар ажиллаж байна.</p> <p><b>4.1.1.4. төрийн жинхэнэ албан хаагчийн томилох, чөлөөлөх, асуудлыг төрийн өндөр албан тушаалтан болон улс төрийн намын нөлөөллөөс ангид байлгах</b></p> <p>Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлыг хуулийн дагуу хэрэгжүүлж байна. Тус яаманд 2019 онд томилогдсон 8 албан хаагч Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хуулийн холбогдох заалт, шалгуурыг хангасан, зөрчилгүй томилогдсон байна. Улс төрийн намын гишүүн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч байхгүй.</p> <p>- 2019 онд УУХҮЯ-нд төрийн албаны шалгалт өгөөгүй буюу төрийн албаны төв байгууллага, Авлигатай тэмцэх газарт ХАСУМ хянуулаагүй, хууль журам зөрчсөн томилгоо хийгдээгүй. Хүүхэд асрах чөлөөтэй байгаа гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтний ажлын байранд ажлын шаардлагаар англи, япон хэлний өндөр чадвартай Б.Отгонжаргалыг сонгон түр ажилд авсан бөгөөд төрийн албаны шалгалт өгөх шаардлагатай тухай мэдэгдэл өгсөн. Хүүхэд асрах чөлөөтэй байгаа Г.Энхзулын чөлөөний хугацаа 2020 оны 5 дугаар сард дуусч ажилдаа ороход түр ажиллаж байгаа Б.Отгонжаргалыг чөлөөлнө.</p> <p>- Тус яам улс төрийн албан тушаалтан 2, сайдын ажлын албаны 4, төрийн үйлчилгээний 3, төрийн захиргааны 69, нийт 78 албан хаагчтай. Төрийн захиргааны 69 албан хаагч бүгд төрийн албанд хуулийн дагуу томилогдсон, 2019 оны 12 дугаар сард томилогдсон 1 албан хаагчаас бусад 68 албан хаагч төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөсөн жинхэнэ албан хаагчид юм.</p> <p><b>4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах</b></p> <p>- УУХҮЯ нь Засгийн газрын албан хэрэг хөтлөлтийн <a href="https://intranet.gov.mn/">https://intranet.gov.mn/</a> цахим системд нэгдэн, программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг программыг ашигласнаар Засгийн газрын хэрэг эрхлэх газар, бусад яамд, агентлагуудтай өдөр тутамд сүлжээнд холбоотой байж, мэдээлэл шуурхай солилцох боломж бүрдсэн.</p> <p><b>4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх</b></p> <p>- Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн 64.3-т Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын</p>
--	------------------------	---

		<p>байгууллага ажиллана гэж заасан. Энэ заалтын дагуу Удирдлагын академийн дэргэд Төрийн албаны сургууль байгуулагдан, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлсэн. 2019 онд Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан тэргүүн түшмэлийн багц сургалтад Төрийн нарийн бичгийн дарга, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 13 нэгжийн дарга, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 8 ахлах мэргэжилтэн тус тус хамрагдсан.</p> <p>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 140 дүгээр тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2017-2020 онд хэрэгжүүлэх төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “УУХҮЯ-ны төрийн албан хаагчдыг 2019 оны сургалтын төлөвлөгөө”-нд ажлын байран дахь мэргэшүүлэх, хувь хүнийг хөгжүүлэх, давтан сургах 4 чиглэлээр 24 сургалт төлөвлөснөөс эхний хагас жилд 16 сургалт, сүүлийн хагас жилд үлдсэн 8 сургалтыг зохион байгуулсан байна. Сургалт зохион байгуулах, албан хаагчдыг суралцах нөхцөл боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх тал дээр анхаарч сургалтад жигд хамруулж байна.</p>
<p><b>4.1.2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх</b></p>		
	<p>ЭБАТ</p>	<p><b>4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх</b></p> <p>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2019 онд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> сайтад байршуулсан. Иргэд олон нийтээс санал сэтгэгдэл хүлээж авах бүх боломж хангагдсан.</p>
	<p>Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар</p>	<p><b>4.1.2.4. эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох</b></p> <p>- Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын тайланг хагас жил тутам авч эрсдлийг тооцон зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн хяналт дотоод аудитыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>- АМГТГ, “Эрдэнэс таван толгой” ХК-д байгууллагын дотоод хяналтын албадтай хамтран дотоод аудит хийх байнгын удирдамжийг УУХҮСайдаар батлуулан аудит хийлээ.</p> <p>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/51 дүгээр тушаалаар батлагдсан байнгын удирдамжийн хүрээнд АМГТГ-т “Нөөцгүй болон нөөц тодорхойгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл”, “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл”-ийн байдалд тус тус нийцлийн аудит хийж 10 заалттай зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/22 дугаар</p>

	тушаалаар “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 19 заалттай зөвлөмж хүргүүлж зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллав.
<b>4.1.3. Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</b>	
Санхүүгийн хэлтэс	<p><b>4.1.3.2. төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх талаар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багц, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төсвийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтын байдлыг шилэн дансанд мэдээлсэн мэдээлэлд тулгуурлан сар бүрийн 15, 25-ны өдрүүдэд явцын хяналтыг тогтмол тавин ажиллаж, улирал бүрийн 10-ны дотор тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. 2019 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар шилэн дансны мэдээлэлд дотоод аудит хийж 4 зөрчилд хугацаатай зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллав.</li> <li>- Мөн УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/107, А/203 дугаар тушаалуудаар эд хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогын комиссыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар ахлуулан ажиллаж, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулан ажиллаа.</li> <li>- Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой ямар нэг гомдол санал ирээгүй болно.</li> </ul>
Санхүүгийн хэлтэс	<p><b>4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2019 онд Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын багцад Засгийн газрын тусгай сангаас хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.</li> </ul>
Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар	<p><b>4.1.3.6. нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сангийн сайдын баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын дагуу санхүүгийн хяналт, дотоод аудитыг зохион байгуулж байна. Хяналт шалгалтын давхардлыг арилгах, санхүүгийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна.</li> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/87 дугаар тушаалын дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд суман дах “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨААТҮГ-ын 2017-2018 оны үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж 6 заалттай зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтийг хангуулав.</li> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/186 дугаар тушаалын дагуу “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” Төслийн нэгжийн 2017-2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж 6 заалттай зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтийг хангуулав.</li> <li>- Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор УУХҮС-ын эрхлэх</li> </ul>

	асуудлын хүрээний төсвийн 11 байгууллагад тухай бүр, 7 хоног, сар, улирал бүр хяналт тавьж хугацаа хоцорч болон мэдээлэл байршуулаагүй 57 зөрчилд зөвлөмж хүргүүлэн 1 ажилтанд сахилгын арга хэмжээ тооцуулан, илэрсэн зөрчлийг цаг тухай бүр нь засуулан мэдээ тайлан нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
Санхүүгийн хэлтэс	<p><b>4.1.3.7. аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах</b> 2018 оны жилийн санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>- Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2019 оны 04 сарын 25-ны дотор Үндэсний аудитын газраас аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт өгсөн. Аудитиар нийт 11 зөвлөмж өгөгдсөн. Нийт өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т албан тоотор хүргүүлж шилэн дансанд байршуулсан. Сайдын багцын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийг 89,9 хувь ханган ажилласан. Сайдын багцын тайланд төсөвт байгууллага 2, Төрийн өмчит үйлдвэрийн газар 17 нэгтгэгдэж байгаагаас 2 байгууллага хязгаарлалтай санал дүгнэлт бусад байгууллагууд зөрчилгүй санал дүгнэлт авсан. Нийт сайдын багцын хэмжээнд 3 акт тавигдсан бөгөөд зөрчлийг арилгах, зөвлөмжийг 100% ханган ажилласан.</p> <p><b>4.1.3.10. төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтийн алба, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг иргэд, олон нийтийн хяналтад оруулах</b> - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын тайлангийн биелэлтийг Шилэн дансны тухай хуулийн дагуу 2019 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор яамны цахим хуудсанд шилэн дансны мэдээлэлд байршуулсан.</p>
	<b>4.1.4. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх</b>
Санхүүгийн хэлтэс	<p><b>4.1.4.1. тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх</b> - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг сайдын 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулав. Захиалагч буюу УУХҮЯ-ны 2019 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтын тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр шуурхай зохион байгуулан, тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайт, өдөр тутмын сонинд нийтэлж, Шилэн дансанд тендерийн явц, үр дүнг тухай бүр оруулж, дараах хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон, хяналт тавьж ажиллалаа. Үүнд:</p> <p>- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг мөрдлөг болгон ажиллах,</p> <p>- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй</p>

	<p>Санхүүгийн хэлтэс</p>	<p>тендер шалгаруулалтын аргаар хуулийн дагуу зохион байгуулах,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр шуурхай зохион байгуулан, тендерийн урилга үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайтад нийтлэх,</li> <li>- Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоол “Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах,</li> <li>- Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан журмын дагуу Сангийн яаманд хүргүүлж байх зэрэг болно.</li> </ul> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” А/128 дугаар тушаалаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан Сангийн яамаар батлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- УУХҮЯ 2019 онд худалдан авах ажиллагааны 9 тендер зарласан бөгөөд ТНБД-ын 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар байгуулагдсан Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2019.07.08 өдрийн А/113 тушаалаар шинэчлэн байгуулж, 2019.11.11 өдрийн А/195 дугаар тушаалаар татан буулгаж, энэ тендер цуцлагдсан байна.</li> <li>- 2019 онд Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай ТНБД-ын 9 тушаал, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан 4, үнэлгээний хороог татан буулгасан 1, нийт 14 тушаал гарсан байна.</li> <li>- 2019 онд 9 тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд давхардсан тоогоор нийт 82 албан хаагч орж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдүүлэг гаргасан байна. УУХҮЯ-ны 50, гадны байгууллагын 32 иргэн мэдүүлэг гаргасан байна.</li> </ul> <p>Мэдүүлгийн бүртгэлийг хавсаргав. Хавсралт № 06</p> <p><b>4.1.4.2. тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох</b> Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдол, санал байхгүй.</p> <p><b>4.1.4.3. худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Худалдан авах бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахаар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, гишүүдийг цахим системийн сургалтад хамруулж, урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлд нийтэлж, тендерийн үр дүнг сар бүр Шилэн дансанд байршуулан олон нийтэд мэдээллэж ил тод байдлыг ханган ажиллалаа.</li> </ul>
--	--------------------------	--

		<p>- Худалдан авах ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэрийг тухай бүр харьяа байгууллагуудад хүргүүлж, зөвлөмжөөр ханган, хэрэгжилтийг хангуулж ажилласан ба Эх оронч худалдан авах ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг гарган батлуулж, хагас жилийн байдлаар биелэлтийг ЗГХЭГ-т хүргүүлэв.</p> <p>- 2019 онд УУХҮЯ-ны 10 ажилтныг худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх сертификатын сургалтад хамруулсан.</p>
		<p><b>4.1.4.5. санхүүгийн үйл ажиллагаан дахь хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх</b></p> <p>- Хуулийн дагуу Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудитыг жил бүр тогтмол хийж байна.</p>
		<p><b>4.1.6. Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх</b></p>
Хуулийн хэлтэс		<p><b>4.1.6.5. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах</b></p> <p>- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/82 дугаар тушаалаар Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох судалгааг хийж байна.</p> <p>- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль батлагдснаар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм.</p> <p>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/13 дугаар тушаалаар Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим сангийн үр нөлөө, тогтвортой ажиллагааг дэмжих хүрээнд Газрын тосны эрлийн гэрээ болон Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас бичил уурхай эрхлэгч нөхөрлөлтэй байгуулсан гэрээнүүдийг ил тод болгох ажлыг ажлын хэсгийн хүрээнд бэлтгэл ханган, цахим санд байршуулахад бэлэн болгоод байна.</p> <p>- Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан 2 компани газрын тосны ашиглалтын 3 талбайд тос олборлох үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>1. Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт Петрожайна Дачин Тамсаг ХХК 1995 оноос Тамсаг ХХИ, 2007 оноос Тосон уул XIX талбай,</p> <p>2. Дорноговь аймгийн Зүүнбаянд Доншен Монгол газрын тос ХХК 2012 оноос эхлэн олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОҮИТБС/-д хамрагдаж байгаа бөгөөд жил бүрийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 1-р улиралд багтаан ОҮИТБС-ын ажлын албанд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж байна.</p> <p>- Тайланг Сангийн сайдын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 43 тоот тушаалаар баталсан маягтын дагуу хүргүүлдэг байна.</p>
		<p><b>4.1.7. Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачлага, оролцоог дэмжих</b></p>
		<p><b>4.1.7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд,</b></p>



	<p>УУХҮЯ, ЭБАТ</p>	<p><b>олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</b></p> <p>- Авилгатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасан "авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасан "төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх" чиг үүргийг хэрэгжүүлдэг. Эдгээр хуулийн заалт, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудын шударга байдлын түвшинг үнэлэх, авлигын эсрэг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардагдах мэдээллийг цуглуулах зорилготой "Шударга байдлын үнэлгээ"-ний судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг "Эм Эм Си Жи" ХХК-тай хамтран зохион байгуулав. Яамны 20 албан хаагч, харилцагч иргэдээс асуулга авч, хамтран ажилладаг 120 аж ахуйн нэгж, холбоод, ТББ, 5 эрдэмтэн судлаач, 5 хэвлэл мэдээллийн ажилтны хаяг, утас зэрэг мэдээллийг гарган өглөө.</p>
--	------------------------	--

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ